

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
2019 ОНЫ 02 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2019 оны 02 дугаар сарын 28

Багануур дүүрэг

№	Үндэслэл	Хийсэн ажлын биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	БҮТП ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.3	Монгол улсын үндэсний хөгжлийн газар болон GIZ ЭТИС хөтөлбөр хамтран “Жижиг, дунд бизнесийн инновациудыг дэмжих сан”, “Залуу эрдэмтэд, гарааны бизнесийн инновациудыг дэмжих сан”, “Бүтээлч сэтгэлгээ, медиа болон цахимжуулалтын төрлийн инновациудыг дэмжих сан байгуулсан бөгөөд эдгээр сангуудын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд Хүүхдийн модон тоглоомын үйлдвэр байгуулах урьдчилсан төсөл боловсруулж 02.14 – нд хүргүүлсэн.	100%
2	БҮТП ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 16.1	Паркад үйлдвэрүүдийг байгуулах хөрөнгө оруулалтын менежментийг боловсруулж удирдлагад танилцуулсан.	100%
3	БҮТП ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 16.2	Парк-Суралцагч байгууллага байх үйл ажиллагааны хүрээнд УУХҮЯ-аас шилжүүлж байгаа ҮТП-ийн барилгыг хамгаалалтад авах талаар ажилтнуудын дунд хэлэлцэж засварлах урьдчилсан зардлын төсөв гаргах нь зүйтэй байна гэсэн дүгнэлтэд хүрэв.	100%
4	БҮТП ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 17.1.	Бүсүүдийн дэд бүтцийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн дэд бүтцийн зураг төслийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж БХБЯ-руу батлуулахаар шилжүүлээд байгаа бөгөөд гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.	100%
5	БҮТП ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 12. 1	Дүүргийн жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжиж хөгжүүлэх чиглэлээр Дүүргийн ДБҮҮХ, ЖДҮ-тэй хамтрах ажиллах санамж бичгийн төслийг бэлтгэсэн.	100%
6	БҮТП ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 15.1	САТУ компанийн гүйцэтгэсэн паркийн эзэмшил газарт байгаль орчны төлөв байдлын судалгааг БОАЖЯ хүлээн авч цаашид байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх тухай чиглэл өгсөн. Нарийвчилсан үнэлгээний зардлыг төсвөөс гаргуулах арга хэмжээ авах шаардлагатай байна.	100%
7	БҮТП ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1	Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, МУИС болон ШУТИС-иудтай уулзалт хийж хамтран ажиллах чиглэлээр санал солилцов.	100%
8	НЗДТГ-ын ХШҮХ-ийн зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөний 8,9:	<ul style="list-style-type: none"> <li>• Байгууллагад 2019 оны 02 дугаар сард ирсэн 6 бичгийг удирдлагад танилцуулж, чиглэл авч мэргэжилтнүүдэд хуваарилах, албан бичгийн шийдвэрлэлтийг хангуулах, ERP программаар илгээх, бичиг хэргийн стандарт хангахтай холбогдсон ажлыг зохион байгуулав.</li> <li>• Байгууллагаас 2019 оны 02 дугаар сард илгээсэн нийт 13 албан бичгийн 5-ынх нь эх хувийг бэлдэж, хэвлэн гаргаж, e-doc программаар илгээв.</li> <li>• Газрын даргын А тушаал 3, Б тушаал 5-ыг тус тус эхийг нь бэлдэж удирдлагаар</li> </ul>	100%



	<p>хянуулан батлуулав.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Байгууллагад ирсэн бичгийг архивлахад бэлдэн товъёогийг тулгаж байна.</li> <li>• Байгууллагаас 2018 явуулсан 187 бичгийг архивлахад бэлтгэж, товъёогийг тулгав.</li> <li>• Хамт олны хурлын протокол 3 үйлдэн газрын удирдлагад танилцуулан баталгаажуулав.</li> </ul>	
<b>Нэмэлт ажлууд</b>		
9	“МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн тодотголд тус паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг 2019-2021 онуудад тусгуулах тухай саналаа Үндэсний хөгжлийн газарт холбогдох материалуудын хамт 19 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	100%
10	Монгол улсын Үндэсний хөгжлийн газар болон GIZ ЭТИС хөтөлбөр хамтран “Жижиг, дунд бизнесийн инновациудыг дэмжих сан”, “Залуу эрдэмтэд, гарааны бизнесийн инновациудыг дэмжих сан”, “Бүтээлч сэтгэлгээ, медиа болон цахимжуулалтын төрлийн инновациудыг дэмжих сан” байгуулсан бөгөөд эдгээр сангуудын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд: <ul style="list-style-type: none"> <li>▪ Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх үйлдвэр, Багануур цахилгаан механикийн үйлдвэрээс гарах төмрийн хаягдал хэрчдэсээр бэлэг дурсгалын зүйл хийх үйлдвэр, Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооноос будаг гаргах үйлдвэр, Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооны элсээр зүлгүүр хийх үйлдвэрийн инновацийн урьдчилсан төслүүдийг боловсруулж 02.14-ны өдөр InnovationfundMongolia@gmail хаягаар Нийслэлийн Инновацийн санд хүргүүлэв.</li> </ul>	100%
11	2019 онд хэрэгжүүлэх Иргэдийн оролцоотой хөгжлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан.	100%
12	НЗДТГ-ын ХШҮХ-ийн зөвлөмжийн хүрээнд байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
13	УУХҮЯ, МИНИС төсөл болон GREENTRENDS-ийн хамтран зохион байгуулсан “Нүүрснээс нийлэг байгалийн хий гарган авах үйлдвэр байгуулах төслийн бүс нутгийн байгаль орчны үнэлгээний тайлангийн төсөл”-ийн олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон.	100%
14	УХЗАА болон ЭМНБХ-гээс зохион байгуулсан хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвшье сэдэвт сургалтад хамрагдсан.	100%

ХЯНАСАН:

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:



*Б. Мичид-Эрдэнэ*

Ч.ЭЛБЭГСАЙХАН

“Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨТҮГ-ын дарга

Д.Алтангэрэл  
Ахлах мэргэжилтэн

Б.Мичид-Эрдэнэ  
Эдийн засаг, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн